



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: statograaffairs@parliament.mn
<http://www.parliament.mn>

2022.11.22 № 52

"Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн
үйл ажиллагааны талаар асуулга
тавих тухай

Монгол Улсын газрын тосны баталгаат нөөцийг 306,6 сая тонн, үүнээс ашиглалтын баталгаат нөөцийг 41,2 сая тонн гэж ашигт малтмалын нэгдсэн санд бүртгэсэн байна.

Манай улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ жил тутам 7-10 хувийн хооронд хэлбэлзэн нэмэгдэж байгаа бөгөөд 2025 онд газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ 2.5 сая тонн болно гэж тооцоолж, газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулснаар нийт хэрэглээний 55 хувийг хангах боломжтой гэж үзжээ.

1991 онд УИХ-аас баталсан Газрын тосны тухай хуулийн дагуу 1993 онд АНУ-ын "Снайдер ойл" корпорац газрын тосны хайгуулын Дорнод аймгийн Буйр ХХII талбайд, "Медалион ойл" компани Тосон-Уул XIX талбайд, 1995 онд Снайдер ойл корпорац Тамсаг-XXI талбайд "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-г тус тус байгуулсан байна.

Дээрх хоёр талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээг Хятадын үндэсний газрын тосны корпорацийн харьяа төрийн өмчит "Дачин ойл фийлд лимитед" компани нь 2005 оны 04 дугаар сарын 01-ний өдөр "Соко Интернэйшнл плс" компаний "Хувьцаа худалдах, худалдан авах тухай" гэрээ байгуулснаар 1993 онд байгуулсан Тосон-Уул XIX, 1995 онд байгуулсан Тамсаг XXI талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлэн авсан аж.

Тус компани 1998-2021 онд 9.5 сая тонн газрын тос, түүхий нефтийг БНХАУ руу экспортолсноос 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар 4.33 баррель буюу 586.7 мянган тонн газрын тос олборлож, 4.10 сая баррель буюу 556.6 мянган тонн газрын тос экспортолжээ.

Манай улс газрын тос олборлодог боловч газрын тосны бүтээгдэхүүнээ 100 хувь гадаад зах зээлээс импортолж ирсэн бөгөөд 2021 оны байдлаар 1.8 сая тонн газрын тосны бүтээгдэхүүнийг 1.1 тэрбум амдоллароор худалдан авсан байна.

Монгол Улсын хууль тогтоомж шинэчлэгдэхийн хэрээр анх байгуулж байсан Бүтээгдэхүүн хуваах тухай гэрээ нь өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудтай зөрчилдэх явдал ихээр гарах болжээ.

Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр нийт олборлосон тосны 40 хувийг БНХАУ-ын компани хайгуул, олборлолт хийхэд зарцуулсан хөрөнгө оруулалтаяа нөхөх зориулалтаар авч байгаагаас гадна үлдсэн 60 хувь тосны 40 хувийг Монгол Улс

. 2022000129

авч, улдэх 60 хувийг гэрээлэгч тал авч байгаа буюу өөрөөр хэлбэл, 100 хувь тосны 24 хувийг Монгол Улс, 76 хувийг гэрээлэгч тал авч байна.

Түүнчлэн дээрх компанийн НӨАТ, ААНОАТ, хувь хүний орлогын албан татвар, нехэн төлбөртэй холбоотой 312,0 тэрбум төгрөг, нийгмийн даатгалтай холбоотой 4,7 тэрбум төгрөгийн маргаантай асуудал өнөөдрийг хүртэл бурэн шийдвэрлэгдээгүй тухай мэдээлэл байна.

Мөн нефтийн бүтээгдэхүүний үйл ажиллагаанаас гардаг хатуу, шингэн, авто машины аюултай хог хаягдал, химийн бодисын сав, баглаа боодол, хэрэгцээнээс давсан, хугацаа хэтэрсэн химийн бодис зэрэг байгаль орчинд сөрөг, аюултай нэлөө үзүүлэх хортой бодис, хог хаягдлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Засгийн газраас 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдөр Газрын тосны ашиглалтын "Тосон-Уул-XIX", "Тамсаг-XXI" талбайнуудад байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх үүргийг шилжүүлэн авсан "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-тай бүтээгдэхүүн хуваах гэрээг дүгнэх, гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх асуудлыг шийдвэрлэх ажлын хэсгийг Монгол Улсын шадар сайд С.Амарсайханаар ахлуулан байгуулсан байна.

Түүнчлэн Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа Тамсагбулагийн сав газрын Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд үйл ажиллагаагаа явуулж байгаа "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн үйл ажиллагааны талаарх Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсож, "Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай" Байнгын хорооны 03 дугаар тогтоолыг батлан гаргасан.

Уг тогтоолоор Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр болон газрын тосны салбарын хөрөнгө оруулалт, экспорт, эрэл хайгуул, ашиглалт, олборлолт, байгалийн неөц, нехэн сэргээлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Засгийн газарт тодорхой асуудлуудаар чиглэл өгсөн бөгөөд энэ тогтоолын биелэлтийг Байнгын хороонд 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосон билээ. Энэ асуудал танилцуулагдаагүй байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1.Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2022 оны 03 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар;

2.Монгол Улсын шадар сайд С.Амарсайханаар ахлуулсан Газрын тосны ашиглалтын "Тосон-Уул-XIX", "Тамсаг-XXI" талбайнуудад байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх үүргийг шилжүүлэн авсан "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-тай бүтээгдэхүүн хуваах гэрээг дүгнэх, гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсгийн явцын талаар;

3."Петрочайна Дачин Тамсаг" ХХК-д тавьсан татварын болон нийгмийн даатгалтай холбоотой маргааныг хэрхэн шийдвэрлэсэн талаар;

4.Ашигт малтмалын тухай болон Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд хэзээ өргөн мэдүүлэх гэж байгаа талаар;

5. Газрын тос боловсруулах үйлдвэрийн явц байдал, үйлдвэрийг түүхий эдийн тогтвортой нөөцийн хангах бэлтгэл ажлын талаар.

Дээрх асуулгын хариуг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар сонсож, хэлэлцүүлэх төлөвлөгөөтэй байгаа тул асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Б. БАТТӨМӨР

2022000129